

Сангийн сайдын 2013 оны 5
дугаар сарын 31-ний өдрийн 125
дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

**ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ
БАРИМТ БИЧИГ**

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.

**ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар

БАТЛАВ.
ЦССҮТ-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Огноо: 2023.01.26

ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр: **Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ
үзүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын
тендер**

Тендер шалгаруулалтын
дугаар:

ЦССҮТ/202301001/02

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2023.01.26

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэгэх ажил** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2023 оны 1 сарын 31-ний өдрийн 10 цагаас** өмнө **Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн төв байр, 405 тоот** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2023 оны 1 сарын 31-ны өдрийн 11:00¹**-т нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авчболно.

Хаяг: **Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-49, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн зүүн хойд талд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн төв байр 405 тоот**

Захиргаа, маркетингийн албаны Эдийн засагч, статистикч Ш.Соёлмөнх

Утасны дугаар: 99073433; 70112857

Цахим шуудангийн хаяг: nctmstatistic@gmail.com

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыгхангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээдгарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн нийж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэжирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн нүнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болоннийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг

гүй
цэтг
эсн
ий
төл
бөр
ийг
зах
иал
агч
хий
хгүй
ба

бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийндагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

5. Үнийн

саналын
хүчинтэй байх
хугацаа

6. Алдааг залруул ах

- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөнбол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

(в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид

гэрээ

байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуул
ахэрх
олгох
тухай
мэдэгдэ
л**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт шаардлага</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт /2021 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт/ 2. Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл <i>2022 онд ижил төстэй ажил гүйцэтгэснийг нотлох гэрээний хуулбар, гэрээ байгуулсан байгууллагын ажлын гүйцэтгэлийн тухай тодорхойлолт, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлэх</i>
ТӨӨЗ 1.2	<p>Үйлчилгээ гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл: “Шаардана”</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын удирдах болон ахлах албан тушаалтан нь тусгай чиг үүргийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх 2. Алба хаагчдаа Цагдаагийн байгууллагаас зохион байгуулдаг сургалтад тогтмол хамруулсан байх /гэрчилгээний хуулбар/ 3. Санал болгож буй харуул хамгаалалтын ажилтнууд нь мэргэжлийн гэрчилгээ, сертификат, харуул хамгаалалтын ажлын 1 жилээс доошгүй туршлагатай талаар тодорхойлолт ирүүлэх 4. Санал болгож буй харуул хамгаалалтын ажилтнууд нь соёл ч боловсон харилцаатай, хамгаалалтын албанд тэнцэх бие бялдар, эрүүл мэндийн шаардлага хангасан байх ба насны дээд хязгаар 55 настай байх 5. Боловсон хүчний жагсаалт хавсаргах
ТӨӨЗ 1.3	<p>Үйлчилгээ гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана”</p> <ol style="list-style-type: none"> 1. Харуул хамгаалалтын постыг эргэх тусгай тоногдосон автомашинтай байх /Автомашинны гэрчилгээний хуулбар/ 2. Харуул хамгаалалтын ажилтан албан хаагчдыг дүрэмт хувцас, формоор хангадаг байх 3. Тусгай хэрэгсэл (радио станц, гав, резинэн ба цахилгаан бороохой, нулимс асгаруулагч газ, резинэн ба хуванцар сумтай буу гэх мэт хэрэгслээр хангасан байх) /жагсаалт, зураг, танилцуулга нотлох баримтыг ирүүлэх/

ТОӨЗ 1.4	<p>Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /хүчинтэй байх/ 2. Харуул хамгаалалтын ажлын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 3. Радио давтамж ашиглах эрхийн зөвшөөрөл
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-49, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн зүүн хойд талд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн төв байр 405 тоот</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 4 давхар 405 тоот Огноо: 2023 оны 1 сарын 31-ний өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн төв байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 4 давхар сургалтын заал</p> <p>Огноо: 2023 оны 1 сарын 31-ний өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p>

БАТЛАВ.
ЦССҮТ-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР

Дөрөв. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2023 оны 01 сарын 23 өдөр

Д.Д	ҮЗҮҮЛЭЛТИЙН НЭР	ҮР ДҮН
1	Байрлал	Улаанбатар хот, Баянзүрх дүүргийн 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-49, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн зүүн хойд талд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн төв байр, Улаанбаатар хот СҮхбаатар дүүрэг, 1-р хороо С.Зоригийн гудамж Улсын нэгдүгээр төв эмнэлгийн залгаа Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2-р байр.
2	Объектийн талбай	Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн төв байр 800 м2 газартай, барилга байгууламжийн хувьд 3200 м2 албан контор, цус цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, түгээх олгох хэсгийн зориулалтын байр, авто машины граж, агуулах, бетонон хучилттай автомашины зогсоолтой, гадна зүлэг, мод ногоон байгууламжтай. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн залгаа Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2-р байр 800 м2 талбай бүхий 1 давхар цус цуглуулах хэсэг, агуулах, улсын нөөцийн цус цусан бүтээгдэхүүн хадгалах хүйтэн агуулах, гамшгийн үеийн бэлэн байдлын нөөц төв, гадна талай, төмөр хайс, мод ургамал зүлэг ногоон байгууламжтой.
3	Тус объектонд ажиллах хүч, цагийн хуваарь	Тус байр /объект/ нь 24 цагийн турш байнгын харуул хамгаалалтад байна. Объект тус бүрд тогтмол 1 харуул ажиллуулах бөгөөд алба хаагчийн ердийн ажлын өдрийн үргэлжлэл өглөө 09:00 цагт ажил хүлээлцсэнээр эхэлж дараа өдрийн өглөө 09:00 цагт ажил хүлээлцсэнээр дуусна.
4	Шуурхай алба /эргүүл/	Болзошгүй гэмт аюул, хулгай, дээрмийн үед бэлэн ажиллах 24 цагийн шуурхай эргүүлтэй байх, давхар хяналт тавих нөхцөл бүрдсэн байх
5	Аюулгүй байдлын дохиолол	Галын болон дулаан, халуун, хүйтэн , цэвэр усны шугам сүлжээний аюулгүй байдлыг хянах
7	Үйлчлүүлэгчийн эд хөрөнгө, бараа материал	Төвийн 1, 2 дугаар байр болон /нийт объект/ оффис доторх албан хэрэгцээний компьютер, тоног төхөөрөмж, ширээ сандал бусад албаны өмчлөлийн эд зүйлс, архивын өрөө, авто машины граж, төвийн 00 давхар буюу склад/агуулах/-ын бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хадгалах

8	Үйл ажиллагааны талаар	Объектийн талаархи мэдээллийг холбогдох албан тушаалтануудад тайлагнах, тухайн ээлжинд гарсан хамгаалалтын ажилтнууд илтгэх хуудас бичих, ээлж хүлээлцсэн тухай тэмдэглэл хөтлөх, сар бүр ажлын бичмэл тайлан өгөх
9	Объектийн дотор дэг журам	Гадны, сэжигтэй, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн оруулахгүй, уулзах хүнээс нь ажилтнаас нь зөвшөөрөл авч оруулж байх. Дэг журам алдагдсан үйлдэл гарч бусдын амь нас, бие, эрүүл мэнд, эд зүйлд хохирол учирч болох нөхцөл үүссэн, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхүйц гаднаас гэмт хэргийн шинжтэй хандлага үйлдсэн, хулгай, дээрэм, танхай хэрэг зөрчил гарсан нь өөрөө зогсоох боломжгүй үед тусгай хэрэгслийг хэрэглэх, таслан зогсоох, тухайн тохиолдолд үйлчлүүлэгч байгууллагын удирдлагад нэн даруй мэдэгдэж байх. Хууль хяналт болон цагдаагийн байгууллагатай нягт хамран ажиллах, гэмт хэрэг, зөрчлийг мэдээлэх
10	Нэмэлт ажил	Байгалийн үзэгдэл их хэмжээний цас бороо, салхи шуурганы үед хамтарч тусалж ажиллах, авто зогсоол зохицуулах

АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙРШИЛ, ҮНЭ, ХУГАЦАА

№	Объектын байршил	Нийт төсөвт өртөг	Объектын зориулалт	Хамгаалалтын үйлчилгээ авах хугацаа
1	Улаанбаттар хот, Баянзүрх дүүргийн 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-49, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн зүүн хойд талд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн төв байр, Улаанбаатар хот СҮхбаатар дүүрэг, 1-р хороо С.Зоригийн гудамж Улсын нэгдүгээр төв эмнэлгийн залгаа Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2-р байр.	18,500,000	Төрийн үйлчилгээний байгууллага	2023.02.01 - 2022.6.31

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлынхуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадалшгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр саналболгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг,

тамга: Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх**
 - 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр**
 - 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх**
 - 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал**
 - 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
 - 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа**
 - 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх**
 - 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
7. **Ажлын хөтөлбөр**
 - 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
 - 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдолилрүүлэх**

- 8.1. Төслийн менежер гүйцэтгэчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
9. **Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа² дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд
10. **Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцожгүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. **Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. **Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. **Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги³ төлнө. Алдангийн нийт

дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 15.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төсл баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт засвар** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

- 18. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 19. Гэрээг цуцлах**
- 19.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэжүзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 19.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөдэдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 19.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 20. Гэрээг цуцалсан үедхийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалынүнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл

- дуусаагүй
ажлын
гэрээний
тусгай
нөхцөлд
заасан
хэмжээг
дээрх
үнэлгээнэ
эс хасна.
Нэмэлт
алданги
гүйцэтгэгч
ид
- ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 21. Гүйцэтгэлэ
эс
чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ⁴

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: ЦССҮТ/202301001/02
ГЕН 2.1	Ажил нь <i>[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусадгэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ.
ГЕН 3.1	Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяг]</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр 2023.02.01 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2023.05.31
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 2 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <i>[тоо]</i> хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна. ⁶ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 5 хувь байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -ртооцно.

⁴ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁵ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁶ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр]
гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний
дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийнхот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны__сарын____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийтгүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө,бусдыг нь устгана/
Улсын төсвөөс: 20.... онд: _____төгрөг; 20.... онд: _____төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____төгрөг; 20.... онд: _____

_____төгрөг;Өөрийн хөрөнгө:20.... онд: _____төгрөг;

20.... онд: _____төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____байршилтай _____ хүчин чадал бүхий _____ам.метр талбай / _____шоо метр эзлэхүүн/-тай,

_____суурь, _____хана, _____хучилттай, _____давхар _____барилга угсралт /барилгын засвар,

тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____инженерийн шугам сүлжээ /дулаан,

цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____туслах барилга /бусадажил/-ын хамт _____оны _____дугаар сарын _____-ны өдөр эхэлж,

_____оны _____дугаар сарын

____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Техникийн тохорхойлолт
- 5.6. Зураг
- 5.7. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.8. Санхүүжилтийн хуваарь;
- 5.9. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг] [Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ТАМГА

[Захиалагчийн хаяг] [Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

9.1.